



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2025 ОН**

“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК

2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд парк нь 2025 оны хагас жилийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна. Энэ хугацаанд:

- Монгол Улсын Засгийн газрын тогтоол - 1
- Нийслэлийн Засаг даргын захирамж – 7
- Төрийн болон бусад байгууллагаас нийт 341 албан бичиг ирснээс хариутай албан бичиг нь 92 байж хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагаас бусад байгууллага, аж ахуй нэгжүүдэд нийт 323 албан бичиг явуулсан.

НЭГ. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО: 3.3.1. БАГАНУУР, БАГАХАНГАЙ, НАЛАЙХ, ЭМЭЭЛТ ДЭХ ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ДЭД БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ДУУСГАХ ТАЛААР:

1.1.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дулааны станц барих хөрөнгийн эх үүсвэрийг улс нийслэлийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийх нөхцөл боломжийг судлах

- Паркийн дулааны станц барих хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2026 оны төсөв, МУ-ын 2025-2028 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар саналаа хүргүүлсэн. Мөн ХББОС-ын яаманд дэд бүтцийн ажлын хөрөнгө оруулалтыг тусгуулах хүсэлт хүргүүлсэн. Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгуулсан.

1.2.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн шугам сүлжээний төсвийг шинэчлэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг судлах

- Дэд бүтцийн төсвийг шинэчлэх ажлын нэмэлт хөрөнгө болох 60,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад албан хүсэлт хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулгад дэд бүтцийн барилга байгууламжуудын хөрөнгө оруулалтыг 2026 оны төсөвт тусгуулах албан хүсэлт хүргүүлсэн.

1.3.110/10кВ-ын 2х16 мВА чадалтай дэд станцын угсралтын ажлыг бүрэн дуусгах ажилд хяналт тавих

- Цахилгаан хангамжийн БУ-ын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Уг барилга байгууламжийн “Налайх 110/35/10 кВ-ын дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил” дэд станцаас Паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын БУА дэд станцын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөлийн ажил Дэд станцаас паркийн 110/10 кВ-ын дэд станц хүртэлх 110 кВ-ын 2 хэлхээт 9,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил бүрэн дуусаж техникийн комисс ажилласан бөгөөд цахилгааны горимын тооцоол хийгдэж, техникийн комиссоос өгсөн үүрэг даалгавруудыг бүрэн хийж дуусгаж 72 цагийн туршилт тохируулгын ажил амжилттай болж улсын комисс ажиллаж ажлыг хүлээж авсан.

ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДСАН ЗОРИЛГО: 3.3.2. БАГАНУУР, НАЛАЙХ, БАГАХАНГАЙ ДҮҮРЭГТ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙГ ДАГАЛДАХ БУСАД ҮЙЛДВЭРИЙН ХАМТ БАЙГУУЛАХ ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ ТАЛААР:

2.1.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн ХЕТ боловсруулах ажлыг эхлүүлэх

- Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Хот байгуулалт, хотын стандартын газрын дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтсийн дарга Ч.Бадамханд, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулгад 60 га газрын ХЕТ-г боловсруулах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлсэн. Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн 60 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар боловсруулан батлуулж Нийслэлийн Хот байгуулалт, Хотын стандартын газрын 2026 оны зураг төсвийн төлөвлөгөөнд тусгуулсан.

2.2.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн дэд бүтцийн барилга байгууламжуудын гадна цахилгаан хангамжийн зураг төсөв боловсруулах ажлыг эхлүүлэх

- Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт гадна цахилгаан хангамжийн зураг төсөв боловсруулах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлсэн.

2.3.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн ТЭЗҮ, Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлэх

- ШУТИС-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулж Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах эрдэмтдийн багийг сонгон гэрээ байгуулан төлөвлөгөөний үе шат бүрт хамтран ажиллаж төлөвлөгөөнд тусгах саналаа хүргүүлэн паркийн Хөгжлийн төлөвлөгөө /2025-2040/-г боловсруулан хүлээн авч Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Хөгжлийн төлөвлөгөөг АҮЭБЯ-ний мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх хүсэлтээ хүргүүлж хоёр шинжээч томилогдон ажиллаж байна. ТЭЗҮ шинэчлэх хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, ЭЗХЯ-д албан бичиг хүргүүлсэн

2.4. Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн 250 га газарт техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх

- ШУТИС-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд Техник, технологийн түвшний үнэлгээг тус сургуулийн тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн багаар хийлгэхээр санал солилцож байна.

2.5.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх

- БОННУ хийх компанийг сонгох талаар 3 байгууллагаас үнийн санал авсан бөгөөд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллагуудад хүсэлт гаргасан.

2.6.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн 310 га газрын хянан баталгаа хийлгэх

- “Хөдрөгцэцүүх” ХХК, “Дээшлэх говь” ХХК, “Дорнын байгаль” ХХК –аас 310 га газрын хянан баталгаа хийлгээр үнийн судалгаа авсан. Хянан баталгаа хийлгэх 21,5 сая төгрөгийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Амгаланд албан тоот хүргүүлсэн.

2.7.Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авах

- Паркийн Хөгжлийн төлөвлөгөө /2025-2040/-г боловсруулан хүлээн авч Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Хөгжлийн төлөвлөгөөг АҮЭБЯ-ын мэргэжлийн зөвлөлөөр батлуулж, паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Мөн тусгай зөвшөөрөл авахад шаардагдах аж ахуйн нэгжийн БОНУ, ТЭЗҮ, ХЕТ, ТТТҮ-ний бүрдлийг хангасан.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

3.1.Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй хамтран ажиллаж паркийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааг эрчимжүүлэх

- Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 3 удаагийн хурал хийсэн бөгөөд хурлаар ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, дэргэдэх хороод, хороодын бүрэлдэхүүн, компанийн гүйцэтгэх захирал, бүтэц орон тоо, төсөв санхүүг баталсан. Мөн тусгай зөвшөөрөл сунгахтай холбогдуулан паркийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-д танилцуулж, АҮЭБЯ-ний

мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх хүсэлтээ хүргүүлж хоёр шинжээч томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу парктэй гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн гэрээг дүгнэх ажлын хэсгийг байгуулж, дүгнэлт тайланг ТУЗ-ийн хурлаар танилцуулсан.

3.2.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах

- Нийслэлийн төсвөөс 2025 онд 800,0 сая төгрөг батлагдсан бөгөөд батлагдсан төсөв, зорилтод түвшний хүрээнд ажиллаж байна. 2025 оны 2 улирлын байдлаар 400,0 сая төгрөгийн санхүүжилт авч, өр, авлага үүсгэлгүй, төсвийг 2 хувиар хэмнэн ажиллаж байна. Он дамжсан, урт хугацааны хариуцагч нь олдохгүй эрэн хайлгаж байсан өр, авлагын баримт материалыг бэлдэж хуулийн байгууллагаас зөвлөгөө аван компанийн ТУЗ-ийн 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 8 дугаар тогтоолоор хүчингүй болгож ажиллаа.

3.3.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн аж ахуйн нэгжийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх

- Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоогийн байдлаар 250 га газар дээр шинэчилсэн гэрээ хийсэн 15 аж ахуй нэгж 2025 онд шинэ гэрээ хийсэн 15 аж ахуй нэгж нийт 30 аж ахуй нэгж газар ашиглуулах гэрээ байгуулан ажиллаж байна. 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт үйлдвэрийн барилга угсралтын ажлаа эхлүүлээд байгаа бөгөөд бүтээн байгуулалт 85 хувьтай явагдаж байна. Дээрх үйлдвэрүүд ашиглалтад орсноор 325 хүнийг байнгын ажлын байраар хангах ба одоогоор 8 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхлээд байна. 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдөр аж ахуй нэгжийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх, бичиг баримтын бүрдлийг хангах чиглэл өгсөн. Паркаас олгогдсон үйлдвэрийн газар дээр хашаа татсан 15-н аж ахуй нэгжийн газар дээр хяналтын кадастр хийхэд 4 аж ахуй нэгж олгогдсон газраас илүү татсан зөрчлийг гарсан зөрчил арилгах албан мэдэгдэл хүргүүлээд байна. Мөн паркийн 250 га дээр “Модун Артель групп” ХХК-аар дрон зураг авалт хийлгэж байна. Ажил 80%

3.4.Улс, нийслэлийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2025 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх.

- Төсөв санхүүгийн үйл ажиллагаанд хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг тухай бүр байгууллагын вэб сайт болон мэдээллийн самбарт мэдээлсэн.

3.5.Мэдээллийн ил тод байдлыг хангах, байгууллагын цахим хуудсанд үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тогтмол тавьж мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран хурал, зөвлөгөөн зохион байгуулж, судалгаа хийх.

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын вэб сайт, пэйж хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан:

- Үйл ажиллагааны ил тод байдал,
- Хүний нөөцийн ил тод байдал,
- Төсөв, санхүүгийн ил тод байдал,
- Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн дөрвөн төрлөөр мэдээ мэдээллүүдийг тогтмол болон цаг тухай бүрт нь мэдээлэн ажиллаж байна.

3.6.Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, танилцуулга материал, товхимлуудыг түгээж, хамтарсан уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.

- Гадаад томилолт – 2
- Зочид төлөөлөгчид – 17

- Албан уулзалт – 7,
- Олон улсын цахим хурал – 0,
- Сургалт, семинар -5
- Гэрээ -33
- санамж бичиг-4 тухай бүрт нь байгууллагын үйл ажиллагааны болон, шаардлагатай хөрөнгө оруулалт, цаашид хийгдэх ажлын тухай мэдээллийг танилцуулж, хамтран ажиллах боломжуудыг эрэлхийлж ажилласан.
- 2025 оны 01 сарын 08-ны өдөр Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар, Туркийн Хамтын ажиллагаа, Зохицуулах агентлагийн Улаанбаатар дахь Хөтөлбөр зохицуулах газрын Зохицуулагч Муслу Алитай уулзалт хийсэн. Уулзалтаар 2 талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, уялдаа холбоог сайжруулах талаар хэлэлцээр хийсэн бөгөөд Паркийн сургалтын өрөөг тохижуулах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх тал дээр нэгдсэн байр сууринд хүрч чадсан. Сургалтын өрөөг иж бүрэн тохижуулснаар Паркийн нэгж үйлдвэрүүд төдийгүй Налайх дүүргийн төрийн болон хувийн байгууллагууд бүх төрлийн сургалтын үйл ажиллагааг, техник технологийн өндөр чанар бүхий орчинд зохион байгуулах боломж бүрдэнэ.



- 2025 оны 01 сарын 31-ний өдөр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүд үйлдвэрлэл, технологийн паркийн талаарх бодлогын хэрэгжилттэй танилцсан. Уулзалтаар Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар паркийн танилцуулга тавьж, үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн.



- 2025 оны 02 сарын 06-ны өдөр Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар НҮБ-ын Хүүхдийн сангийн Шадар суурин төлөөлөгч Ян Му-тай албаны уулзалт хийсэн. Уулзалтаар хүүхдийн тэгш хүртээмжтэй хөгжлийн гарааг дэмжих, хүүхдийн эрхийг дээдлэн хамгаалах, хүрээлэн буй орчны эрүүл ахуй, хүүхдийн аюулгүй байдлыг хангах зэрэг үндсэн 10 зарчмыг хэрэгжүүлэн ажилладаг НҮБ-ын хүүхдийн сантай хамтран ажиллах боломжтой 3 төслийн талаар санал солилцсон. Суурин төлөөлөгч Ян-Му нь НҮТП дээр байрших ААНБ-ууд болон НҮБ -ын хүүхдийн сангийн хооронд гүүр болон ажиллах, хүүхдийн эрхийг дээдэлсэн, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүхий бизнесийн орчинг бүрдүүлэх төсөл санаачлагыг дэмжин хамтран ажиллана гэдгээ илэрхийлсэн.



- 2025 оны 02 сарын 12-ны өдөр Аж үйлдвэржилтийн үндэсний хорооны анхдугаар хуралдаанд НҮТП-ийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар танилцуулга хийж. Тус танилцуулгад паркийн өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжүүлсэн ажлууд болон цаашдын төлөвлөлттэй холбоотой мэдээллүүд мөн Үйлдвэр технологийн паркуудын хоорондын уялдаа холбоог хангаж, үйл ажиллагаа болон хөгжлийн чиглэлүүдийг дэмжихийн тулд олон арга хэмжээ авах шаардлагатай байгааг онцолсон бөгөөд одоогийн цаг үеийн тулгамдсан асуудлуудыг тодорхой танилцуулсан.



- 2025 оны 02 сарын 14-ны өдөр МГХАМТИС-ийн Санхүү, захиргаа хариуцсан дэд захирал Б.Энхбаяр, Институцийн эдийн засаг, менежментийн профессор Ч.Энхзаяа, Хүрээлэн буй орчны инженерийн профессор Г.Гантуяа нар Паркийн удирдлагуудтай албан уулзалт хийсэн. Уулзалтаар Үйлдвэрлэл технологийн паркийн ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг илүү тодорхой болгох, МГХАМТИС-ийн эрдэмтдийн багаар ахлуулсан хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлуудыг шат дараатайгаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Уг уулзалт нь Үйлдвэрлэл технологийн паркийн судалгаа, шинжилгээний олон ажлын эхлэл болж байгаа бөгөөд цаашид ШУТИС-ийн эрдэмтдийн баг болон гадаад улс орнуудын зөвлөх багуудтай ажиллах санал нэгдсэн.



- 2025 оны 02 сарын 27-ны өдөр Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, аж үйлдвэржүүлэлтийг нутагшуулах үүднээс Монголын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн нэгдсэн холбооны тэргүүн Р.Батгэрэл болон Гүйцэтгэх захирал н.Өлзийбаатар нартай уулзалт зохион байгуулсан. НҮТП-ын бүс нутгийн хөгжлийг хамтран тодорхойлж, паркийн системд оролцогч талуудын түншлэл, хамтын ажиллагааг кластерын тогтолцоогоор хөгжүүлэх чиглэлд орон нутаг, төрийн захиргааны төв байгууллагуудтай бодлогын түвшинд хамтран ажиллах санамж бичиг хийхээр харилцан тохиролцсон.



- 2025 оны 03 сарын 11-ний өдөр Налайх дүүргийн удирдлагууд болон БНХАУ-ын “Хуанан Жүншин Хуанбао” группийн уулзалт паркийн хурлын танхимд болсон. Уулзалтаар Налайх дүүрэгт тулгамдаад буй Дулааны станцын газар сонголт, барилга угсралтын ажил эхлүүлэх хугацаа, 5000 айлын орон сууцны төслүүдийг ярилцаж, харилцан тохиролцоог хийсэн. Цаашид УТП болон Налайх дүүрэг нь харилцан уялдаатай хамтран ажиллаж паркийн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг ашиглан барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх, шинээр баригдах дулааны станцыг түүхий эдээр хангах талаар ярилцсан.



- 2025 оны 03 сарын 13-ны өдөр ОХУ-ын салбар дундын мэргэжилтнүүдийн үүсгэн байгуулсан хөрөнгө оруулалтын компанийн зохицуулагч Михаил Владимирович Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа, өнөөгийн түвшин, хөрөнгө оруулалт хийх саналуудтай танилцаж мэдээлэл солилцсон. Тус паркийг ОХУ-ын үйлдвэрлэл, технологийн паркуудын хөгжилтэй уялдуулан стратеги төлөвлөлт болон паркийн хөгжлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын чиглэлээрх үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж үзсэн.



- 2025 оны 03 сарын 21-ны өдөр БНСУ-ын Засгийн газар түнш орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх бодлогын хамтарсан судалгаа, хөгжлийн талаар зөвлөгөө өгөх, 2025 онд “Монгол Улсад аж үйлдвэрийг хөгжүүлэх стратеги (хүнд үйлдвэрт чиглэх)” төслийг хамтран хэрэгжүүлэх судлаачдын баг НҮТП-т ажилласан. НҮТП-ийн Гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар албаны хүмүүсийг хүлээн авч танилцуулга мэдээлэл хийсэн. НҮТП-ийн Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд болон бусад чиглэлээр хамтран ажиллах боломжтойг илэрхийлсэн.



- 2025 оны 03 сарын 21-ний өдөр Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай даргаар ахлуулсан ажлын хэсэг “ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД” сэдэвт хэлэлцүүлгийг Нийслэлийн ҮТП-ийн удирдлагуудтай хамтран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт НЗДТГ, Хот байгуулалт, хотын стандартын газар, газрын дарга нар оролцсон. Паркийн удирдлагууд үйл ажиллагааны явц, Төр хувийн хэвшлийн түншлэл, хамтын оролцоо болон тулгамдаж буй асуудлуудыг танилцуулж цаашид хууль эрх зүйн орчин эдийн засгийн нөхцөл боломжинд тулгуурлан шат дараатайгаар асуудлуудыг хамтран шийдвэрлэж ажиллахаар шийдвэрлэсэн.



- 2025 оны 03 сарын 26-ны өдөр Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК-ийн удирдлагууд парктай гэрээ байгуулж бүтээн байгуулалт, үйлдвэрлэлээ эхлүүлсэн аж ахуйн нэгжийн удирдлагуудыг хүлээн авч уулзсан. Хувийн аж ахуйн нэгжүүд өөрсдийн тулгамдаж буй асуудлуудын талаар саналаа хуваалцсан бол паркийн зүгээс дэд бүтцийн ажлуудын талаар танилцуулж, аж ахуйн нэгжүүддээ хөрөнгө оруулалтаа болон бүтээн байгуулалтаа эрчимжүүлж ажиллахыг үүрэг

болгосон. Аж ахуйн нэгжийн удирдлагууд Техник технологийн түвшний үнэлгээ хийх ажилд паркаас удирдан зохион байгуулж, дэмжлэг үзүүлэхийг хүссэн.



- 2025 оны 03 сарын 26-ны өдөр БНХАУ-ын төрийн өмчит China CAMC Engineering Co., Ltd-ийн Инженерийн хэлтсийн ерөнхий инженер ноён Мао Зоу паркийн төлөвлөлт болон үйл ажиллагаатай танилцсан. Паркийн зүгээс Бөөний болон жижиглэн худалдааны төвийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Багахангай дүүрэгт байрлалтай тээвэр ложистикийн зориулалттай талбайн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах саналыг тавьсанаар Төрийн өмчит компани дэмжиж хамтран ажиллахаа илэрхийлсэн.



- 2025 оны 04 сарын 02-ны өдөр “Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Парк” ХК (НҮТП) болон Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль (ШУТИС) хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Талууд есөн чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон бөгөөд цаашдын үйл ажиллагаа зөвхөн эдгээр чиглэлээр хязгаарлагдахгүй. Паркийн үйлдвэрүүдийг хөгжүүлэхэд эрдэмтэн, судлаачдын бүтээл, шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн.



- 2025 оны 04 сарын 17-ны өдөр НҮТП болон Шинжлэх ухаан, технологийн их сургууль (ШУТИС)-ийн хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд хэрэгжих ажлын эхлэл тавигдсан. Уг ажлын хүрээнд ШУТИС-ийн дэд профессор М.Бурмаагаар ахлуулсан эрдэмтэн, судлаачдын баг Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын явц, үе шаттай холбоотой танилцуулга хийсэн. Хөгжлийн төлөвлөгөө нь тухайн компанийн бизнес төлөвлөгөө бус, харин Монгол Улсад аж үйлдвэрийн шинэ эрин үеийг эхлүүлэхэд чиглэсэн урт хугацааны стратеги төлөвлөлт гэдгээрээ онцлог.



- ШУТИС болон НҮТП-ийн хамтын ажиллагааны хүрээнд “Их сургууль–Үйлдвэрлэл” түншлэлийг өргөжүүлэх зорилготой арга хэмжээ зохион байгуулагдсан. Уг үйл ажиллагаанд ШУТИС-ийн проректор Д.Цолмонбаатар, албаны дарга М.Зулбаяр, НҮТП-ийн гүйцэтгэх захирал Ч.Раднаабазар болон паркийн нэгжүүдийн төлөөлөл оролцсон. Хамтын ажиллагааны хүрээнд судалгаа, туршилт, чанар стандарт, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих олон талт үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх боломжийг талууд ярилцаж шийдвэрлэхээр болсон.



- 2025 оны 04 сарын 28-ны өдөр Налайхын үйлдвэрлэл, технологийн парк ХК (Nalaikh ITP LLC) болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Жижиг, дунд бизнесийн бодлогын хүрээлэн (KISME) хооронд харилцан ойлголцлын санамж бичиг (MOU) байгуулсан. Энэ санамж бичиг нь Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Паркийг төлөвлөх, хөгжүүлэх, олон улсын түвшинд сурталчлах, хөрөнгө оруулалт татах, аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагааны ноу-хау солилцох зэрэг чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой.



- 2025 оны 04 сарын 29-ны өдөр НҮТП-ийн төлөөлөл болон АҮЭБЯам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Жижиг, дунд бизнесийн бодлогын хүрээлэнгийн төлөөлөгчид Дорноговь аймгийн Засаг дарга Т.Батжаргалтай уулзалт зохион байгуулсан. Уулзалтын хүрээнд бүсийн хөгжлийн бодлого, чиглэлийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийж, хоёр улсын хамтын ажиллагааны боломж, хөгжлийн шинэ гарцын талаар санал солилцсон. Энэ үеэр Алтанширээт Үйлдвэрлэл, технологийн паркт хийгдэж буй бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын явцтай газар дээр нь танилцсан бөгөөд уг бүтээн байгуулалт нь бүс нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжилд чухал нөлөө үзүүлэх хүлээлттэй байна.



- 2025 оны 05 сарын 06-ны өдөр ТИКА-ийн суурин төлөөлөгч Налайхын ҮТП-ийн үйл ажиллагаатай танилцаж уулзалт хийсэн. Тус уулзалт НҮТП-ийн байранд зохион байгуулагдсан бөгөөд өмнөх уулзалтаар танилцуулсан төсөл, хөтөлбөрүүдтэй газар дээр нь танилцаж, цаашдын хамтын ажиллагааны чиглэл, хөгжлийн боломжуудын талаар санал солилцсон. ТИКА-ийн төлөөлөгчийн зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ур чадварыг нэмэгдүүлэх зорилго бүхий сургалт, мэдээллийн төвийн төслийг хамтран хэрэгжүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлсэн бөгөөд цаашид олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинэ төслүүдийг дэмжин ажиллахаа онцолсон.



- 2025 оны 05 сарын 16-ны өдөр Дархан-Уул аймгийн “Монгол Оюу” ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчид НҮТП-тай танилцсан. Төгсөх ангийн сурагчдын ирээдүйн мэргэжил сонголтод чиглүүлэх зорилготой уг уулзалтад 50 гаруй сурагчид оролцож мэдээлэл авч паркийн нэгж болох “Электрокем” ХХК-ийн үйлдвэртэй танилцсан.



- 2025 оны 05 сарын 27-ны өдөр Австралийн Queensland University-ийн багш профессор Шарма НҮТП-ийн үйл ажиллагаатай танилцаж хамтран ажиллах талаар санал солилцсон. Аж үйлдвэрийн салбарт дутагдалтай байгаа ажиллах хүчний нөөцийг нэмэгдүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр хамтран ажиллахад нээлттэй гэдгээ илэрхийлсэн.





- 2025 оны 05 сарын 28-ны өдөр парктай гэрээ байгуулан ажиллаж буй “Эморс констракшн” ХХК-ийн хөрөнгө оруулагчид НҮТП-ийн үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл авсан.




- 2025 оны 06 сарын 01-ний өдөр БНХАУ-ын хөрөнгө оруулалтын компани НҮТП-ийн үйл ажиллагаатай танилцсан. Паркийн зүгээс Цэвэрлэх байгууламж болон Төмөр замын төслүүд дээрээ хамтран ажиллах санал тавьсан.



- 2025 оны 06 сарын 04-ний өдөр Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвийн хамт олон НҮТП-т ажилласан. Тус байгууллагын зорилго нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд чиглэж байна. МУ-ын хэмжээнд үйлдвэрлэл эрхэлж буй нийт үйлдвэрлэл эрхлэгчдийн 97% нь жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэсэн статистик мэдээлэл бий.



- 2025 оны 06 сарын 05-ны өдөр БНХАУ-ын хөрөнгө оруулалтын компанийн төлөөллүүд НҮТГП-тай танилцсан. Паркийн зүгээс Цэвэрлэх байгууламж болон Дулааны станцын дэд бүтцийн ажлууд дээрээ хөрөнгө оруулалт татах ТХХТ-ийг хэрэгжүүлэн ажиллах саналуудаа тавьсаар байна.



- 2025 оны 06 сарын 06-ны өдөр “Багануур” ҮТГП-ийн үйл ажиллагаатай танилцсан. Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 4 ҮТГП нь хоорондын уялдаа холбоотой, кластер хэлбэрээр хөгжих бүрэн боломжтой гэдгийг энэ удаагийн үйл ажиллагаа бататган харуулсан. Багануур ҮТГП-тай гэрээ байгуулан паркийн нэгжээр элсэн орсон 3 ААН-ийн үйл ажиллагаатай танилцсан бөгөөд тэдгээр үйлдвэрүүд нь бүтээгдэхүүнээ зах зээлд гарган нийлүүлж аль хэдийнээ хэрэглэгчидтэй болсон байна.



- 2025 оны 06 сарын 10-ны өдөр “Эрхзүйн шинэчлэл - Хөгжлийн татах хүч” уриатай “ИТР ФОРУМ-2025” арга хэмжээ Төрийн ордны Чингис хаан танхимд зохион байгуулагдсан. Монгол улсын аж үйлдвэржилтийн хөгжлийг дэмжих, үйлдвэрлэл технологийн паркуудын эрхзүйн орчныг боловсронгуй болгоход үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид сайжруулах, үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд үйлдвэрлэл эрхлэх хувийн хэвшлийнхэнд төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмрээ оруулах зорилготой. Арга хэмжээнд УИХ-ын Аж үйлдвэржилтийн байнгын хороо, ЗГ-ын Хэрэг эрхлэх газар, АҮЭБЯам болон МҮХАҮТ, Монголын үйлдвэрлэл, технологийн паркуудын холбоо, төрийн болон хувийн өмчит ҮТГП-уудын төлөөллүүд 130 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон.



- 2025 оны 06 сарын 12-ны өдөр Багануур ҮТП-ийн хамт олныг хүлээж авч уулзсан. Тус паркийн төлөөлөл цаашид паркийн удирдлагуудад болон нэгжүүдэд ХАБЭА-ийн сургалтыг зохион байгуулах талаар саналаа хэлж, хамтран ажиллах боломжтой гэдгээ илэрхийлсэн. ХАБЭА-н сургалтыг тусгай зөвшөөрөлтэй сургагч багш буюу мэргэжлийн байгууллага хийх эрхтэй байдаг.
- 2025 оны 06 сарын 25-ны өдөр Итали улсын мод, модон эдлэл, модон байшингийн Үндэсний үйлдвэрлэгч 100 жилийн түүхт Legno Camuna үйлдвэрийн төлөөлөгчид ҮТП-тай танилцаж, хөрөнгө оруулалт хийх, үйлдвэрийн салбараа барих талаар уулзалт зөвлөгөөн хийсэн. Тус компани нь ОХУ-ын Буриад улсад өөрсдийн мод бэлтгэлийн томоохон үйлдвэртэй бөгөөд тэнд бэлтгэгдсэн модыг авчирч жижиглэх, хэлбэрт оруулах замаар модон сууц бэлтгэх төсөл хэрэгжүүлэх хүсэлтэйгээ илэрхийлсэн. Бэлтгэгдсэн модон сууцыг Монгол улсад болон олон улсын зах зээлд гаргах төлөвлөлтийг танилцуулсан.



- 2025 оны 06 сарын 27-ны өдөр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-ээс зохион байгуулсан “Эрчим хүчний тэгш, хүртээмжтэй шилжилт Форум”-д оролцсон. Тус форум нь Налайх дүүрэг болон JET-CR Платформ хамтран зохион байгуулсан арга хэмжээ бөгөөд МУ-д эрчим хүчний тэгш, хүртээмжтэй шилжилтийн талаар хэлэлцүүлэг өрнүүлж, өнөөгийн нөхцөл байдал, боломж болон тулгамдаж буй сорилтуудыг хэлэлцэх зорилготой. Форумын үеэр НҮТП хийж хэрэгжүүлэх боломжуудыг онцолж, оролцож буй талуудын хамтын ажиллагааг дэмжиж, түүний ач холбогдлыг онцолсон юм.



- 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр ҮТП-ийн гүйцэтгэх захирал БНХАУ-ын Шиан хотод үйлдвэрлэл, технологийн паркуудтай танилцах, хөрөнгө оруулагчдад төслийн мэдээллээ өгөх, туршлага судлах зорилгоор гадаад томилолт хийсэн бөгөөд энэ үеэрээ “Шаан-ши Дүн-Зэ өндөр технологийн үйлдвэрлэл” ХХК-тай хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн хүрээнд талууд барилгын бөөний болон жижиглэн худалдаа үйлчилгээний цогцолборын 60 га талбайн ХЕТ хийх, Барилгын материалын үндсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх чиглэлийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, ҮТП-ийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажилд шаардлагатай санхүүжилтыг эрэлхийлэх ажлуудыг эрчимтэй зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.
- 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр “Барилгын материал – Тохирлын гэрчилгээ – Итгэмжлэл” сэдэвт хэлэлцүүлэг семинарыг ҮТП-ийн хурлын танхимд зохион байгуулсан. Тус семинарыг Үндэсний итгэмжлэлийн төв болон НҮТП хамтран зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэг семинарын үр дүнд паркийн нэгжүүд олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд хэрхэн анхаарах, тохирлын гэрчилгээ авах процессийг түргэвчлэх онол аргазүйн мэдээллүүдийг авсан.
- 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр БНСУ-ын эрдэм шинжилгээний ажилчдын багыг хүлээн авч уулзсан. Тус уулзалтаар НҮТП-ийн паркийн талаарх мэдээллийг хүргэж, хамтран ажиллах боломжуудын талаар ярилцсан. БНСУ-ын эрдэм шинжилгээний ажилчид нь ЖДҮ-ийн салбарын хөгжлийн гарцыг танилцуулж, цаашид үйлдвэрлэлийн бүс нутгийн хөгжлийн төлөвлөлтийг хэрхэн хийвэл үр ашигтай байх талаар, олон улсын зах зээл дээрээс хэрхэн хөрөнгө оруулалт татах арга замуудыг танилцуулж, хамтран ажиллах бүрэн боломжтой гэдгийг илэрхийлсэн.



- 2025 оны 08 дугаар сарын 01-ны өдөр БНСУ-ын Жонбуг аймгийн Уонгуан их сургуулийн захирал, төлөөлөгчдийн хамт айлчилж уулзалт хийсэн. НҮТП-ийн зүгээс паркийн мэдээллийг өгч тус Их сургуулийн оюутнуудыг паркт танилцуулах, паркт ажиллах сонирхолтой оюутнуудыг оюутан солилцооны журмаар сургах тал дээр голчлон анхаарч буйгаа илэрхийлсэн. Уонгуан их сургууль нь Инженер, Боловсрол, Байгалийн ухаан болон бусад чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг бөгөөд аймгийн тэргүүний их сургууль юм. ҮТП-ийн хөгжлийн төлөвлөлт болох эрдэм шинжилгээ судалгааны төвийг голчлон сонирхож буйгаа илэрхийлээд тус төвийн бүтээн байгуулалт, үйл ажиллагааны нэг хэсэг болон хамтарч ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Сургуулийн удирдлагууд Налайх дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтран төгсөх ангийн оюутнуудыг өөрийн сургуульдаа урьж суралцуулах замаар мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхээр хамтран ажиллахаар бэлтгэл ажилдаа орсон.



- 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр БНСУ-ын хөрөнгө оруулалтын мэргэжлийн байгууллага болох Artist Sum-ийг үүсгэн байгуулагчид паркийн үйл ажиллагаатай танилцсан. Тус хөрөнгө оруулалтын байгууллага нь олон улсын хөрөнгө оруулалтын сангуудтай хамтран ажиллаж, шаардлагатай дэд бүтцийн


хөрөнгө оруулалтыг оруулдаг бөгөөд НҮТП-ийн дэд бүтцүүдэд хөрөнгө оруулагч татах, танилцуулах ажлыг гэрээний үндсэн дээр хийх бүрэн боломжтой гэдгээ илэрхийлсэн. Гэрээ байгуулагдсанаар паркийн мэдээллүүдийг авч шууд ажлаа эхлүүлэх боломжтой болох юм.



- 2025 оны 09 сарын 12-ны өдөр Монголын уул уурхайн салбарын хамгийн том арга хэмжээ болох “Mining week & MinePro 2025” олон улсын үзэсгэлэн, чуулга уулзалтад НҮТП өөрийн танилцуулгыг олон нийтэд сурталчилж, паркийн Гүйцэтгэх захирал бүс нутгийн хөгжлийн зөвлөгөөнд панелистаар оролцсон. Арга хэмжээнд оролцогчид паркийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг бөгөөд паркийн бүтээн байгуулалтуудыг сурталчлах томоохон үйл явдал болдог юм. 3 өдрийн турш зохион байгуулагдсан арга хэмжээнд давхардсан тоогоор 1000 орчим иргэд, ААН-үүдэд мэдээлэл хүргэсэн.



- 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Энэтхэгийн хөрөнгө оруулалтын сангийн мэргэжилтнүүдэд паркийн танилцуулга мэдээллийг өгсөн. Тус сан нь дэд бүтэц болон үйлдвэрлэлийн салбарт голчлон хөрөнгө оруулалт татдаг олон улсын мэргэжлийн байгууллага юм.



- 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр НИТХ-ын төлөөлөгч, НҮТП-ийн ТУЗ-ийн дарга З.Төмөртөмөө, НИТХ-ын төлөөлөгч Т.Батцогтын хамт НҮТП-т БНХАУ-ын хөрөнгө оруулагчдын хүсэлтээр авчран паркийн үйл ажиллагаатай танилцуулсан. Нийслэлийн өмчит ХК болох НҮТП-ийн дэд бүтэц, үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалтаа оруулж ТХХТ-ийн гэрээг байгуулан ажиллах нь ямар үр ашигтай болох талаарх мэдээллийг өгч хамтран ажиллах боломжуудын талаар нээлттэй ярилцсан.



- 2025 оны 10 сарын 08-ны өдөр НҮТП ХК болон “Дуртмал ус” ХХК-ийн хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. “Гүнээсээ хайрлая” усны шилдэг шийдлийн шалгаруулалтын 2025 оны шилдэг байгууллагаар шалгарсан “Дуртмал ус” ХХК нь Монгол орны байгалийн эрдэс түүхий эдэд тулгуурлан үйлдвэрийн болон ахуйн бохир ус цэвэрлэх зориулалттай МЖ-В коагулянт бодисыг Монгол Улсад анх удаа гарган авч, туршилт судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэж байна. Налайхын Үйлдвэрлэл, Технологийн Парк ХК тус компанитай хамтран ажилласнаар үйлдвэрлэлийн бүсэд үүсэж буй бохир усыг цэвэршүүлж, саарал ус болгон дахин ашиглах технологийг паркийн аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх боломж бүрдэж байна. Энэ нь байгаль орчны бохирдлыг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулах юм. Түүнчлэн дүүргийн гэр хорооллын айлуудын хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр төлөвлөлт хийж ажиллахаар харилцан тохиролцож хамтран ажиллахаар болсон.



- 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдөр ОХУ-ын бага оврын дулааны станцын төсөл НҮТП-т танилцуулагдлаа. Тус компани нь айл өрх, албан байгууллагад ашиглах боломж бүхий түлшээр ажилладаг, зөөврийн дулааны станцыг үйлдвэрлэхээр үйлдвэрийн төслийг танилцуулсан бөгөөд хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлсэн.



- 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр СЭЗИС-ийн эрдэмтдийн баг Налайх дүүрэг болон НҮТП-ийн талаар хийгдсэн судалгааг танилцуулсан. Доктор Т.Батжаргалаар ахлуулсан тус баг нь Налайх дүүргийн Хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд судалгааны ажлын нэг хэсэг болох НҮТП нь Налайх дүүргийн хөгжилд ямар нөлөө үзүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар өөрсдийн судалгаагаа танилцуулж мэдээллийг өгсөн. Паркийн зүгээс судалгааны багт зориулж хэрэглэгдэх бүх шатны мэдээллийг өгөхөд бэлэн гэдгээ илэрхийлж хамтран ажиллах үндсийг тавьж байгаад талархлаа илэрхийлсэн. Тус судалгааны баг Налайх дүүргийн хөгжилд хамгийн их хувь нэмэр оруулах НҮТП-ийн эдийн засгийн үр өгөөжийг тооцоолж гаргасан нь маш оновчтой байсан.



Хүснэгт. Налайх ҮТП-ын Улаанбаатар хотын нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөө					
№	Үзүүлэлт	2025 оны тооцол	Өсөлтийн байдал	2042 оны тооцол	Өсөлтийн байдал
1	ДНБ-н өсрөлт	84 их наяд төгрөг	2,2 хувиар өснө	102,5 их наяд төгрөг	1,9 хувиар өснө
2	Ажлын байрны тоо	212900	Шууд болон шууд бусгаар 1300 ажилтан бусад шинэчлэлээр нэмэгдэнэ	236600	Шууд болон шууд бусгаар 1700 ажилтан бусад шинэчлэлээр нэмэгдэнэ
3	Ядуурлын түвшин	16,1 хувь	0,7 пунктээр буурна	12 хувь	0,3 пунктээр буурна
4	Нэг килад ноогдох ДНБ-ийн өсөлт	10070 доллар	1,9 хувиар өснө	10710 доллар	1,5 хувиар өснө

- 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Налайх дүүрэгт байрлах Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн Герман профессорууд НҮТП-тай танилцсан. Тэдгээр профессорууд нь эхлээд өөрсдөө паркийн талаарх мэдээллийг авч цаашлаад төгсөх ангийн оюутнуудаа танилцуулах, үйлдвэрлэлийн дадлага хийх боломжоор хангах, парктай гэрээ байгуулан ажиллаж буй ААН-үүдэд мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, үйлдвэрлэлийн орчинд сургалтын үйл ажиллагааг явуулах боломжийн талаар харилцан зөвлөлдсөн.
- 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй арматурын үйлдвэрийн төлөөлөл ҮТП-тай танилцах, хамтран ажиллах боломжийн талаар мэдээлэл авсан. Сонгинохайрхан дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй тус компани нь үйлдвэрлэлийг хотын Б бүсээс гаргаж үйлдвэрлэлийн бүсэд байршуулах нь Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, агаар орчны бохирдлоос урьдчилан сэргийлэхэд маш том түлхэц болно гэдгээ танилцуулсан. Паркийн зүгээс татгалзах зүйлгүй бөгөөд хуулийн дагуу бичиг баримтын бүрдэл болон албан хүсэлтээ ирүүлэхийг уламжилсан.



- 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр НҮТП-ийн хурлын танхимд Шүүх шинжилгээний хэлтсийн ил тод байдлын өдөрлөг болж өнгөрсөн. Налайх дүүргийн шүүх шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан уг уулзалт өдөрлөгт Налайх, Багахангай дүүргийн шүүх, прокурорын газар, цагдаагийн хэлтэс оролцсон. Уулзалтаар паркийн үндсэн үйл ажиллагаа, гэрээ байгуулан ажиллаж буй аж ахуйн нэгжүүдийн талаар мэдээлэл хүргэсэн. Цаашид үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэрт аюулгүй байдал, гэмт хэрэг зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөмжийг авч хамтран ажиллахаар санал нэгдсэн.



- 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Нийслэлийн ЖДҮҮДТ-ийн дарга Ундармаа БНХАУ-ын МСС группийн хөрөнгө оруулагчидтай НҮТП-т ажилласан. БНХАУ нь жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн тэргүүлэгч бөгөөд ҮТП-тай хэрхэн хамтарч үйлдвэрлэлийн бүсийг хөгжүүлэх үйл ажиллагааны талаар санал солилцсон.



- 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр МГХАМТИС-ийн Үйлдвэрлэлийн инженерчлэлийн 4-р ангийн оюутнууд Герман профессор Фридрих Тиссенийн хамтаар ҮТП болон паркийн нэгжээр ажиллаж буй Дэлхийн жишиг үйлдвэр “Электрокем Монгол” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцсан. Цаашид эдгээр оюутнуудад төгсөөд ажиллах ажлын байр бэлэн, амьдрах орчин, нийгмийн баталгааг хангах асуудлыг хамтран шийдвэрлэх бүрэн боломжтой юм.



- 2025 оны 11 дүгээр сарын 12-ноос 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд НҮТП-ийн албан хаагчид хүний нөөцийн хөгжлийн төлөвлөлт, хамтын ажиллагааны хүрээнд дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй гэрээ байгуулан 12 модуль хичээлд хамрагдсан. Нийт 12 цагийн 4 удаагийн хичээлд танхим болон цахим хосолсон сургалтуудыг авсан.
- 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр БНХАУ-ын төрийн өмчит хөрөнгө оруулалтын компани болох МСС группийн удирдлагууд ҮТП-тай танилцсан. МУ-ын ЗГ-ын түвшинд хөрөнгө оруулалтын ажил хийхээр гэрээ хийсэн тус компани нь дараагийн төслөөр НҮТП-ийн хөрөнгө оруулалтын ажлыг сонгон ажиллахаа илэрхийлсэн.
- 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр Налайх дүүргийн Ахмадын хорооны гишүүд үйлдвэрлэл, технологийн парктэй танилцаж, үйлдвэрлэл бүтээн байгуулалтын талаар мэдээлэл авлаа. Налайх дүүргийн бүтээн байгуулалт, одоогийн нийгмийн түүчээ болсон ахмадууд маань 3-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж паркт үйлдвэрлэлийн шинэ бүсийг хөгжүүлэн, томоохон хөрөнгө оруулалтуудыг татаж дүүргийн иргэд, хөдөлмөрчдөд орчин үеийн шинэ технологийг нутагшуулах, шинэ ажлын байр бий болгож байгаад талархалтай байсан.

3.7.Архивын үйл ажиллагааг зохион байгуулах

Байгууллагын архивын төлөвлөгөө, архивт баримт хүлээн авах хуваарь, 2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлан хуваарийн дагуу албан хаагчдаас цаасан болон тусгай төрлийн баримтаар нөхөн бүрдүүлэлт хийж данс бүртгэлийг шинэчлэн үйлдсэн.

2024 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 10, хүний нөөцийн чиглэлээр гарсан 42 захирамжлалын баримтыг ArchiveEdoc дэд системд цахимжуулан НАГ-т цахим хувийг хүлээлгэн өгсөн.

Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гарган баталж, шалгалтын агуулга заалт тус бүрийн дагуу бэлтгэн амжилттай шалгуулсан.

Мөн 6 жилд 1 удаа зохион байгуулах архивын баримтын тооллогыг хийж гүйцэтгэсэн.

БНШК-ын хурлыг 3 удаа зохион байгуулж, улсын үзлэгтэй холбоотой асуудал, ХХНЖ болон данс бүртгэлийг хэлэлцэн баталсан.

3.8.Албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах.

Нийслэл, дүүрэг болон холбогдох газруудаас зохион байгуулсан 7 сургалтад давхардсан тоогоор 10 албан хаагчийг хамруулсан

НЗДТГ- Хотын хөгжлийн индексийг тусган боловсруулах арга зүйн сургалт – 2

НЗДТГ – нээлттэй мэдээллийн системд багууллага бүртгэх, мэдээлэл байршуулах, байршуулсан мэдээллийг үнэлэх, хянан баталгаажуулах ажлыг зохион байгуулах албан хаагчийг чадавхжуулах сургалт – 1

Удирдлагын академи – Компанийн засаглалын сургалт – 1

НДЗДТГ – ХАБЭА сургалт - 1

НДЗДТГ - “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим систем” - 3
НАГ – Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн ажлын зохион байгуулалтын улсын
үзлэг шалгалтад заавар чиглэл өгөх тухай – 1
ХНХТ – Монгол бичгийг цахим дээр бичих арга зүйн сургалт – 1

Дотоод сургалтыг 8 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 56 албан
хаагч хамрагдсан.

Налайх дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Сэтгэл зүйн
боловсрол”, “Гэр бүлийн боловсрол”, “Апликэйшн ашиглалтыг чадваржуулах
сургалт”, “Стресс менежмент”, “Эрүүл амьдралын хэв маяг” сэдэвт сургалтуудыг тус
тус зохион байгуулсан.

Налайх дүүргийн Өмгөөлөгчдийн холбооны тэргүүн Б.Чулуунгэрэл
өмгөөлөгчийг урин авчирч Дураараа аашлах, Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт
хэргийн бүрэлдэхүүн сэдвээр сургалт зохион байгуулж 10 албан хаагч хамрагдсан.

Налайх дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран байгууллага
дээр монгол бичгийн анхан шатны 46 академик цагийн сургалтыг зохион байгуулж
8 албан хаагч амжилттай төгссөн.

3.9.Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийг байгууллагын цахим хуудсаар
сурталчлах, албан хаагчдад мэдээлэл өгөх, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон
ажиллах.

- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын
хүрээнд байгууллагын нийт ажиллагсдын хүйсийн тэнцвэрт харьцааг ханган,
жендэрээр ялгаварлан гадуурхах эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх
олгох, хязгаарлалт тогтоох, мөн жирэмсэн, хүүхэд асарсан болон гэр бүлийн
байдлын шалтгаанаар ажилтны хөдөлмөрийн харилцааг дуусгахгүй байх заалтыг
хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.10.Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлж,
төлөвлөгөө гарган ажиллах.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган
төлөвлөгөө гарган ажиллаж байна.

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2025 оны жилийн эцсийн байдлаар)**

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	5	15	Нийслэл, дүүрэг, холбогдох газруудаас зохион байгуулсан 7 сургалтад 10 албан хаагч, дотоод сургалт-8 давхардсан тоогоор 56 албан хаагчийг сургалтад хамруулав
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	8	
			Мэргэшүүлэх сургалт	-	-	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	-	
			Бусад	-	7	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	66	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	46	
			Эрэгтэй албан хаагч	-	20	
			Удирдах албан тушаалтан	-	2	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	8	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	Давхардсан тоогоор 66			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-	-	
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	-	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	-	
			Эрэгтэй албан хаагч	-	-	
			Удирдах албан тушаалтан	-	-	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	-	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш	-	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-	

	хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	-	
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-	50	Цалин, шагнал, урамшуулал нь жилийн нийт төсөвт эзлэх хувь 60 хувь.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-		Ажилчдын хоол унааны зардалд өдрийн 35000 төгрөгийг тооцож олгодог. Хагас жилийн байдлаар 81,480 сая төгрөг олгогдсон.
5.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш		Зохион байгуулагдаагүй болно.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш		100%
6.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-	-	2 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлж 800,000 төгрөг, ахмадын өдрийг тохиолдуулан 2 ахмад ажилтанд нийт 200,000 төгрөг олгосон.

НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Эрхэм зорилго, алсын хараа, тэргүүлэх чиглэл зэргийг цахим хуудсанд байршуулсан. Үйл ажиллагааны чиглэлийн дагуу хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын явцыг цаг тухай бүрт нь мэдээллэж ажилладаг.	100%
1.2.	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Үйл ажиллагааны чиглэл, бүтэц, холбоо барих, санал хүсэлт, албан хаагчдын мэдээлэл, ажиллах цагийн хуваарийг оруулсан. Захиргааны мэргэжилтэн болон Маркетинг хариуцсан мэргэжилтний нэр, албан тушаал, утасны дугаарыг байгууллагын цахим хуудсанд шинэчлэгдсэн тухай бүрт нь байршуулдаг.	100%
1.3.	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Гүйцэтгэх захирлын хариуцлагын гэрээ, биелэлт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны тайланг цаг тухай бүрт нь мэдээллэдэг.	100%
1.4.	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгтийг Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргаж цахим хуудсанд байршуулсан.	100%
1.5.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	“Алсын хараа-2050”, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн хүрээнд тус тус хийгдсэн тайлан, биелэлтүүдийг вэб сайтад оруулсан.	100%

1.6.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	2022 оны 07 сард Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдсан. Мөн бусад хууль тогтоомжуудыг цаг тухай бүрт нь вэб сайтад оруулдаг.	100%
1.7.	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Нийт албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, холбоо барих утас, цахим хаягийг ил тод мэдээлж, өөрчлөгдсөн тухай бүрт нь шинэчлэдэг.	100%
1.8.	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Улирал тус бүрээр тогтмол мэдээллэж ажилладаг.	100%
1.9.	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Барилгын салбарын статистик мэдээллийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас шууд авах боломжтой холбоосыг цахим хуудсанд оруулж өгсөн.	100%
1.10.	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах тухай бүртээ байгууллагын вэб хуудас болон орон нутгийн мэдээллийн цахим хуудсуудаар мэдээллэж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хоёр.Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Сул орон тоо гарсан тухай бүрт нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар, орон нутгийн хөдөлмөр халамжийн хэлтсээр дамжуулан мэдээллэж, орон нутгийн цахим хуудсуудаар мэдээлэл түгээдэг.	100%
2.2.	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Ажилтан сонгон шалгаруулах журам, үе шатыг цахим хуудсанд нийтэлсэн бөгөөд, анкет, албан тушаалын тодорхойлолт, шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрийн тухай мэдээллийг цахим хуудаснаас авах бүрэн боломжтой.	100%
2.3.	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	2025 оны 04 сарын 21-ны өдрийн А/19 тушаалаар Ёс зүйн зөвлөлийн гишүүд, дүрмийг шинэчлэн баталсан бөгөөд байгууллагын цахим хуудсанд өөрчлөгдсөн цаг тухайд нь оруулсан.	100%
2.4.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Шинэ ажилтны дасан зохицох хөтөлбөрүүдийг цахим хуудсанд оруулсан.	100%
2.5.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	Жил бүр шинээр томилогдсон болон ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын мэдээг оруулдаг.	100%
2.6.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Ур чадварын нэмэгдэл олгох журмыг цахим хуудсанд оруулсан.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%

Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх			
3.1.	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Цаг тухай бүрт нь оруулдаг.	100%
3.2.	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг сар бүр оруулдаг. Хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг цаг тухай бүрт нь мэдээллэдэг.	100%
3.3.	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Жил бүрийн аудитын дүгнэлт болон зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг цаг тухай бүрт нь цахим хуудсанд мэдээллэдэг.	100%
3.4.	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Төлбөр хураамж, үйлчилгээний хөлс авдаггүй.	100%
3.5.	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Тухайн мэдээллүүдийг шилэн дансанд цаг тухай бүрт нь байршуулдаг бөгөөд байгууллагын вэб сайтаас шилэн данс руу шууд холбогдох боломжийг бүрдүүлсэн.	100%
3.6.	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;		100%
3.7.	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;		100%
3.8.	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;		100%
3.9.	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;		Шилэн дансны мэдээллийг тогтмол, бүрэн гүйцэт оруулдаг.

3.10.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүр цахим хуудсаар мэдээллэдэг. Байгууллагын зүгээс зарласан тендэр байхгүй.	100%
3.11.	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Шилэн данс	100%
3.12.	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Байхгүй.	100%
3.13.	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Бүтээн байгуулалт болон зураг төслийн ажлын явцын талаарх мэдээллийг тухай бүрт нь байршуулдаг. Мөн улс нийслэлийн төсвөөр хэрэгжүүлж буй ажлуудыг нэгтгэн, оны эцэст мэдээлэл оруулдаг.	100%
3.14.	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Байхгүй.	100%
3.15.	Хууль тогтоомжид заасан бусад.	Улс нийслэлийн төсвөөр хийгдсэн ажлуудын явц, хэрэгжилт, мөнгөн дүнг тогтмол мэдээлж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			
Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
4.1.	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж,	Хамтран ажиллах хүсэлтэй аж ахуйн нэгж, хувь хүмүүст тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл зэргийг цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулдаг.	100%

	зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;		
4.2.	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Тусгай зөвшөөрөл олгодоггүй.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1.	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;	Байхгүй.	100%
5.2.	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	Байхгүй.	100%
5.3.	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Байхгүй.	100%
5.4.	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Эзэмшиж байгаа 4 газрын гэрээ, гэрчилгээг цахим хуудсанд оруулсан.	100%
5.5.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь	Байгууллагын нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, санхүүгийн үйл ажиллагааны мэдээллүүдийг цаг тухай бүрт нь мэдээллэж ажилладаг.	100%

	хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;		
5.6.	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	НИТХ-ын 2024 оны 24/17 дугаар тогтоолоор компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг томилсон бөгөөд хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтын зарыг байгууллагын болон холбогдох цахим хуудсуудаар байршуулан нээлттэй зарлаж сонгон шалгаруулалт явуулсан. НИТХ-ын 2025 оны 25/33 дугаар тогтоолоор ТУЗ-ийн хараат бус гишүүдийг батламжилсан.	100%
5.7.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, тайлан дүгнэлтийг цаг тухай бүрт нь цахим хуудсанд мэдээлж ажилладаг.	100%
5.8.	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг цахим хуудсанд оруулсан.	100%
5.9.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;	Оффисын барилга, худаг, үерийн байгууламж болон авто замын хүлээн авсан акт, дүгнэлтийг цахим хуудсанд оруулсан.	100%

5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк, паркттай гэрээ байгуулсан ААН-үүд хамтарсан гурвалсан гэрээ байгуулахаар гэрээний төсөлд санал авч боловсруулж байна.	80%
5.11	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;	Байхгүй.	100%
5.12	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Компанийн засаглалын сургалтад байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг хамруулсан.	100%
5.13	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.	Байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл, гадаад хөрөнгө оруулагчидтай хийсэн уулзалт, уулзалтын үр дүн, нийгмийн хариуцлагын чиглэлээр хийсэн ажлууд зэрэг мэдээллүүдийг цаг тухай бүрт нь ил тод мэдээлж ажилладаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			98%
Хэрэгжилтийн дундаж хувь:			99,6

ХЯНАСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Ч.РАДНААБАЗАР

Х.БЯМБАА